


Захирлын 2011 оны 11 дүгээр сарын 11-ны
өдрийн 61.2 тоот тушаалын хавсралт 1

УХД-072

СУРГУУЛЬ ХООРОНДЫН ТООЦООНЫ КОЭФФИЦИЕНТ

Д.д	Сургууль нэгжүүд	Коэффициент тооцох хэлбэр		СХТкоэф	Тайлбар
I	Бүрэлдэхүүний сургуулиуд	Лекцийн бүлгийн оюутны тооноос хамаарч	100 хүртэл	0,50	Багц цагийн төлбөрөөс тооцно
II			100-150 хүртэл	0,45	
III			151-с дээш	0,40	
IV	ГХСТөв	Нийт оюутны сонголтоор		0,63	Багц цагийн төлбөрөөс тооцно
V	Биеийн тамир	Нийт оюутны сонголтоор		0,40	2 кредитээр тооцно.



Захирлын 2011 оны 11 дүгээр сарын 11-ны
өдрийн 612 тоот тушаалын хавсралт 2

Сургууль хоорондын тооцоо хийх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

Сургууль хоорондын тооцоо нь бүрэлдэхүүний сургуулиудийн багш нарын бусад сургуульд хичээл заасан цагийн ноогдлыг төлөвлөх, гүйцэтгэл тооцох, сургалтын бодит зардлыг тооцох, өөрийгөө санхүүжүүлэх боломж, эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэхэд оршино.

Хоёр. Сургууль хоорондын тооцоог хийх

- 2.1 Бүрэлдэхүүн сургууль хоорондын багц цагийн тооцоог тухайн улиралд оюутны бүртгүүлж, баталгаажсан багц цагийн тоо хэмжээ, сургууль хоорондын коэффициентийг үндэслэн хийнэ.
- 2.2 Сургууль хоорондын тооцооны коэффициентийг сургууль, нэгжийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан ялгавартай тогтооно.
- 2.3 СЭЗХ нь тухайн хичээлийн жилд мөрдөх сургууль хоорондын тооцооны коэффициентийг өмнөх оны зардлын гүйцэтгэл, орлого, зардлын төсөв, сургууль хоорондын багц цагийн тооцоо зэрэг мэдээллийг үндэслэн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 2.4 Улирлын 4 дүгээр долоо хоногт бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба тухайн улиралд тухайн сургуулиас бусад сургуульд экспортоор заах, импортоор заалгах хичээлийн багц цагийн нэгтгэлийг сургалтын мэдээллийн SiSi системээр гаргах ба экспорт импортоор хичээл заах, заалгах сургуулиудын сургалтын албаны эрхлэгч нар хянаж баталгаажуулсан байна.
- 2.5 Улирлын 5 дугаар долоо хоногт бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын албанаас нягтлан бодогчийнхоо хамт хянаж баталгаажуулсан экспорт, импортын тооцооны нэгтгэлийг Төв сургалтын албанд /Хавсралт-1/ ирүүлэх ба Төв сургалтын алба МУИС-ийн хэмжээний бүрэлдэхүүн сургууль хоорондын багц цагийн тооцооны нэгтгэлийг /Хавсралт-2/ гарган баталгаажуулж, СЭЗХ- т улирлын 6 дугаар долоо хоногт ирүүлнэ.
- 2.6 СЭЗХ нь тухайн улирлын 7 дугаар долоо хоногт Төв сургалтын албанаас ирүүлсэн бүрэлдэхүүн сургууль хоорондын багц цагийн тооцооны нэгтгэл, сургууль хоорондын тооцооны коэффициентийг үндэслэн бүрэлдэхүүний сургууль, нэгж хоорондын өглөг, авлагын дотоод тооцоог хийж, захирлын тушаалаар бүрэлдэхүүн сургуулиудад хүргүүлнэ.
- 2.7 Бүрэлдэхүүний сургууль, нэгжүүд нь МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажсан сургууль хоорондын тооцооны өглөг, авлагыг хоорондоо нэхэмжилж тухайн улирлын 8-9 дүгээр долоо хоногт төлбөрийг барагдуулсан байна.
- 2.8 Биеийн тамирын тэнхмээс үзүүлж буй 3 кредитийг танхимийн сургалтын 2 багц цаг, спортын үйлчилгээний 1 багц цаг гэж ангилах ба нийт багц цагийн төлбөрийг төв санд төвлөрүүлж, биеийн тамирын тэнхимийн сургалт, спорт үйлчилгээний арга хэмжээнд батлагдсан төсвийн дагуу зарцуулна.

Гурав. Сургууль хоорондын тооцоог төлөвлөх, тайлагнах

- 3.1 Бүрэлдэхүүн сургуулиуд нь тухайн хичээлийн жилд сургууль хоорондын багц цагийн тооцоог өмнөх оны орлого, зардлын гүйцэтгэл, тухайн хичээлийн жилд оюутны сонгосон багц цагийн тооцоо, сургууль хоорондын тооцооны коэффициентийг үндэслэн тайлант жилийн төсөвт тусгаж, гүйцэтгэлийг санхүүгийн тайланд тусгана.
- 3.2 Гадаад хэлний төв нь ГХСС –ийн харьяалалд багтах ба төвийн сургууль хооронд үзүүлсэн үйлчилгээний хуримтлуулсан орлого, гарах зардлыг тухайн сургууль нь хариуцна. ГХСС нь төвийн үйл ажиллагааны орлого, зардлын төсвийг зохиож өөрийн сургуулийн төсөвт нэгтгэх ба санхүүгийн тайланд нэгэн адил тусгана.
- 3.3 Биеийн тамирын тэнхмийн сургууль хооронд үзүүлсэн үйлчилгээний багц цагийн орлогыг төвлөрсөн санд төвлөрүүлж, гарах зардлыг санхүүжүүлэх ба тэнхимийн үйл ажиллагааны орлого, зардлын төсвийг төвлөрсөн сангийн төсөвт тусгаж, гүйцэтгэлийг сургуулийн тайланд тусгана.

Дөрөв. Сургууль хоорондын тооцооны хяналт, хариуцлага

- 4.1 Бакалаврын сургалтын алба, Мэдээллийн технологийн алба тухайн улирлын хичээл сонголтын байдал, бүрэлдэхүүн сургуулиас гаргаж байгаа бүрэлдэхүүн сургууль хоорондын багц цагийн тооцоонд хяналт тавьж ажиллана.
- 4.2 Санхүү эдийн засгийн хэлтэс сургууль хоорондын тооцооны төлөвлөлт, гүйцэтгэл тооцох, өглөг, авлагыг барагдуулсан үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.
- 4.3 Захиргаа хяналт-шинжилгээ, үнэлгээний албанаас сургууль хоорондын тооцооны багц цагийн тооцоо, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмжийг холбогдох сургууль, нэгжүүдэд мэдээлнэ.
- 4.4 Бүрэлдэхүүн сургууль хоорондын багц цагийн тооцоог баталгаажуулаагүй, хугацаа хоцруулсан ажилтанд хөдөлмөрийн дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Захирлын 2011 оны 11 сарын 11 ний өдрийн

013 тоот тушаалын хавсралт 3

УХД-072

Сургууль хоорондын тооцоо хийх график

VIII-

№	Хийгдэх ажлууд	Хариуцах	Хугацаа
1	Бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын албадаас оюутан тус бүрээр сонгосон багц цагийн тооцоо, төлбөрийг нягтлан бодогчийн хамт хянаж баталгаажуулан Төв сургалтын албанд ирүүлнэ.	Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба	Тухайн улирлын IV долоо хоногт
2	Бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын албанаас баталгаажуулсан сургууль хоорондын тооцооны нэгтгэлийг Төв сургалтын алба хянаж баталгаажуулна.	Төв сургалтын алба	Тухайн улирлын V долоо хоногт
3	Төв сургалтын алба сургууль хоорондын цагийн тооцоо, нэгтгэлийг хянаж, МУИС-ийн дүнгээр нэгтгэн СЭЗХ-т ирүүлнэ.	Төв сургалтын алба	Тухайн улирлын VI долоо хоногт
4	Төв сургалтын албанаас ирүүлсэн сургууль хоорондын багц цагийн тооцоог хянаж сургууль, нэгж хоорондын төлбөрийн өглөг, авлагын дотоод тооцоог хийж, захирлын тушаалаар бүрэлдэхүүн сургуулиудад хүргүүлнэ.	Санхүү, эдийн засгийн хэлтэс	Тухайн улирлын VII долоо хоногт
5	Сургууль хоорондын тооцооны төлбөрийн өглөг, авлагыг баталгаажуулсан захирлын тушаалын дагуу өглөг, авлагын тооцоог сургууль хооронд нэхэмжилж төлбөрийг барагдуулна.	Бүрэлдэхүүн сургуулийн захирал, нягтлан бодогч нар	Тухайн улирлын VIII-IX долоо хоногт